



НИЙСЛЭЛ ДЭХ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Эрдэнэс Баянбогд ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: НТАГ-2026/143/НА-СТА-ОНӨҮГ

Цахим хуудас:
www.audit.mn
Улаанбаатар хот
2026 он

Нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор **Г.Нандинжаргал**
Утас: 70007734 Цахим хаяг: nandinjargalg@audit.gov.mn
Санхүүгийн аудит хариуцсан
ахлах менежер: **Х.Түвшинбаяр**
Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn
Аудитын менежер: **Д.Отгонбаяр**
Утас: 325093 Цахим хаяг: otgonbayarda@audit.gov.mn
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн:
Ари файнэнс аудит ХХК-ийн захирал: **Д.Ариунаа**
Утас: 99088151 Цахим хаяг: arifin.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2026-03-15 № 716
танай _____-ны № _____-г

ЭРДЭНЭС БАЯНБОГД ХХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
Ц.ОРХОНТАМИР ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, 8.4, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Эрдэнэс Баянбогд ХХК-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудад аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгуудыг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Ашигт малтмал газрын тосны газрын Кадастрын хэлтсийн даргын 2025 оны 397 дугаар шийдвэрээр Дорноговь аймгийн Улаанбадрах сумын Богд уул нэртэй ХҮ-026142 дугаарт бүртгэгдсэн 2808.26 гектар талбайд ашигт малтмалын “Ашиглалтын тусгай зөвшөөрөл”-ийг авсан байна.

Мөн Улаанбадрах 300МВт цахилгаан станц барих ТЭЗҮ-г Эрчим хүчний яамны Шинжлэх ухаан технологийн зөвлөлийн хурлаар баталсан байна.

Аудитын гол асуудал

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг уул уурхай болон цахилгаан станц чиглэлээр нийт 46.0 сая төгрөгийн нээлттэй тендерээр гүйцэтгэгчийг сонгон шалгаруулж, гэрээний дагуу Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний 1 дүгээр үе шат болох байгаль орчны төлөв байдлын үнэлгээ дүгнэлтийг хүлээж авсан байна.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

C:\Users\narangua\Desktop\Баянбогд ХХК-ийн 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан 2026.03.15 1426350832

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 11 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснийг 78.6 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан байна.

Тайлант онд “Төрийн өмчит уул уурхайн компаниудын худалдан авах ажиллагааны цахим системийн ашиглалт, үр дүн” чиглэлээр Үндэсний аудитын газраас хийгдсэн хяналт шалгалтад хамрагдсан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн санхүүгийн тайланд хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



Г.НАНДИНЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Үлдэгдэл	
		1 сарын 1	12 сарын 31
1.1	Эргэлтийн хөрөнгө	365,344,947.17	233,816,627.03
1.1.01	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	351,328,271.05	29,421,827.56
1.1.02	Дансны авлага	543,551.12	179,820,400.00
1.1.03	Татвар, НДШ-ийн авлага	0.00	0.00
1.1.04	Бусад авлага	7,680,000.00	3,147,801.83
1.1.05	Бусад санхүүгийн хөрөнгө	0.00	0.00
1.1.06	Бараа материал	5,747,750.00	6,879,750.00
1.1.07	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	45,375.00	14,546,847.64
1.1.08	Бусад эргэлтийн хөрөнгө	0.00	0.00
1.1.09	Борлуулах зорилгоор эзэмшиж буй эрг-н бус хөрөнгө	0.00	0.00
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	365,344,947.17	233,816,627.03
1.2	Эргэлтийн бус хөрөнгө	5,993,928,634.70	6,428,933,960.43
1.2.01	Үндсэн хөрөнгө	79,889,999.60	54,599,526.43
1.2.02	Биет бус хөрөнгө	56,935,985.54	253,222,385.00
1.2.03	Биологийн хөрөнгө	0.00	0.00
1.2.04	Урт хугацаат хөрөнгө оруулалт	0.00	0.00
1.2.05	Хайгуул ба үнэлгээний хөрөнгө	5,709,130,775.97	5,867,015,836.02
1.2.06	Хойшлогдсон татварын хөрөнгө	147,971,873.59	254,096,212.98
1.2.07	Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө	0.00	0.00
1.2.08	Бусад эргэлтийн бус хөрөнгө	0.00	0.00
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	5,993,928,634.70	6,428,933,960.43
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	6,359,273,581.87	6,662,750,587.46
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ	0.00	0.00
2.1	Өр төлбөр	0.00	0.00
2.1.1	Богино хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.1.01	Дансны өглөг	0.00	0.00
2.1.1.02	Цалингийн өглөг	358,866.44	0.00
2.1.1.03	Татварын өр	12,156,805.05	0.00
2.1.1.04	НДШ - ийн өглөг	0.00	0.00
2.1.1.05	Богино хугацаат зээл	0.00	0.00
2.1.1.06	Хүүний өглөг	0.00	0.00
2.1.1.07	Ногдол ашгийн өглөг	0.00	0.00
2.1.1.08	Урьдчилж орсон орлого	0.00	0.00
2.1.1.09	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.1.10	Бусад богино хугацаат өр төлбөр	6,705,203,445.21	0.00
2.1.1.11	Борлуулах бүлэг хөрөнгөнд хамаарах өр төлбөр	0.00	0.00
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	6,717,719,116.70	0.00
2.1.2	Урт хугацаат өр төлбөр	0.00	0.00
2.1.2.01	Урт хугацаат зээл	0.00	0.00

Эрдэнэс Баянбогд ХХК-ний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

2.1.2.02	Нөөц /өр төлбөр/	0.00	0.00
2.1.2.03	Хойшлогдсон татварын өр	0.00	0.00
2.1.2.04	Бусад урт хугацаат өр төлбөр	881,150,580.00	8,855,744,620.11
2.1.2.06	Урт хугацаат өр төлбөрийн дүн	881,150,580.00	8,855,744,620.11
2.2	Өр төлбөрийн нийт дүн	7,598,869,696.70	8,855,744,620.11
2.3	Эздийн өмч	0.00	0.00
2.3.01	Өмч: - төрийн	100,000,000.00	100,000,000.00
2.3.02	- хувийн	0.00	0.00
2.3.03	- хувьцаат	0.00	0.00
2.3.04	Халаасны хувьцаа	0.00	0.00
2.3.05	Нэмж төлөгдсөн капитал	0.00	0.00
2.3.06	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	0.00	0.00
2.3.07	Гадаад валютын хөрвүүлэлтийн нөөц	0.00	0.00
2.3.08	Эздийн өмчийн бусад хэсэг	0.00	0.00
2.3.09	Хуримтлагдсан ашиг	-1,339,596,114.83	-2,292,994,032.65
2.3.09.1	Тайлангийн үеийн ашиг	0.00	-953,397,917.82
2.3.09.2	Өмнөх үеийн ашиг	-1,339,596,114.83	-1,339,596,114.83
2.3.11	Эздийн өмчийн дүн	-1,239,596,114.83	-2,192,994,032.65
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	6,359,273,581.87	6,662,750,587.46

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Балансын зүйл	Өмнөх оны дүн	Тайлант жилийн дүн
01	Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	0.00
02	Борлуулалтын өртөг	0.00	0.00
03	Нийт ашиг(алдагдал)	0.00	0.00
04	Түрээсийн орлого	0.00	0.00
05	Хүүний орлого	2,293,228.90	1,912,374.06
06	Ногдол ашгийн орлого	0.00	0.00
07	Эрхийн шимтгэлийн орлого	0.00	0.00
08	Бусад орлого	127,725.85	175,939.45
08.1	Орлогын дүн	2,420,954.75	2,088,313.51
09	Борлуулалт, маркетингийн зардал	0.00	0.00
10	Ерөнхий ба удирдлагын зардал	762,400,917.24	1,021,499,333.30
11	Санхүүгийн зардал	0.00	0.00
12	Бусад зардал	0.00	39,920,000.00
12.1	Зардлын дүн	762,400,917.24	1,061,419,333.30
13	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)	0.00	0.00
14	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
15	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)	0.00	0.00
16	Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз)	0.00	0.00
17	Бусад ашиг (алдагдал)	0.00	0.00
17.1	Олз, гарзын дүн	0.00	0.00
18	Татвар төлөхийн өмнөх ашиг(алдагдал)	-759,979,962.49	-1,059,331,019.79
19	Орлогын татварын зардал	-75,997,996.25	-105,933,101.97
20	Татварын дараах ашиг (алдагдал)	-683,981,966.24	-953,397,917.82

Эрдэнэс Баянбогд ХХК-ний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

21	Зогсоосон үйл аж-ны татварын дараах ашиг(алдагдал)	0.00	0.00
22	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	-683,981,966.24	-953,397,917.82
23	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00
23.1	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү	0.00	0.00
23.2	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	0.00	0.00
23.3	Бусад олз (гарз)	0.00	0.00
24	Орлогын нийт дүн	0.00	0.00
25	Нэгж хувьцаанд ногдох суурь ашиг (алдагдал)	0.00	0.00

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
01	2023 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	100,000,000.00	-655,614,148.59	-555,614,148.59
02	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00
03	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00
04	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	-683,981,966.24	-683,981,966.24
05	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
06	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
07	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
08	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00
09	2024 оны 12 сарын 31-ээр үлдэгдэл	100,000,000.00	-1,339,596,114.83	-1,239,596,114.83
10	НББ-н бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга	0.00	0.00	0.00
11	Залруулсан үлдэгдэл	0.00	0.00	0.00
12	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	-953,397,917.82	-953,397,917.82
13	Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
14	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
15	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
16	Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн	0.00	0.00	0.00
17	2025 оны 12 сарын 31-р үлдэгдэл	100,000,000.00	-2,292,994,032.65	-2,192,994,032.65

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
0	Мөнгөн хөрөнгөөс мөнгөн хөрөнгө рүү бичсэн гүйлгээ	0.00	0.00
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,215,175.85	175,000.00
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого	0.00	0.00
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого	0.00	0.00
1.1.3	Даатгалын нөхвөрөөс хүлээн авсан мөнгө	0.00	0.00
1.1.4	Буцаан авсан албан татвар	0.00	0.00
1.1.5	Татаас, санхүүжилтийн орлого	0.00	0.00
1.1.6	Бусад мөнгөн орлого	10,215,175.85	175,000.00
1.2	Мөнгөн зарлагын дүн (-)	1,014,841,057.15	1,124,998,657.40
1.2.1	Ажиллагчдад төлсөн	536,654,205.33	581,492,091.71
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	135,940,935.83	134,513,732.31
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	6,736,356.00	220,046.00
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	2,869,250.00	0.00
1.2.5	Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	6,396,000.00	1,303,000.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	53,049,812.97	72,927,618.36
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	0.00	0.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	273,194,497.02	334,542,169.02
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-1,004,625,881.30	-1,124,823,657.40
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00
2.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,009,702.22	1,913,313.51
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.3	Хөрөнгө оруулалт борлуулсны орлого	0.00	0.00
2.1.4	Бусад урт хугацаат хөрөнгө борлуулсны орлого	0.00	0.00
2.1.5	Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт	7,716,473.32	0.00
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого	2,293,228.90	1,912,374.06
2.1.7	Хүлээн авсан ногдол ашиг	0.00	0.00
2.1.8	Бусад	0.00	939.45
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	5,161,880,810.95	736,767,999.60
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	1,272,600.00	4,100,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	61,363,414.05	373,629,598.50
2.2.3	Хөрөнгө оруулалт олж эзэмшихэд төлсөн	5,099,244,796.90	339,038,401.10
2.2.4	Бусад урт хугацаат хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	0.00	0.00
2.2.5	Бусдад олгосон зээл болон урьдчилгаа	0.00	1,000,000.00
2.2.6	Бусад	0.00	19,000,000.00
2.3	ХО-ын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	-5,151,871,108.73	-734,854,686.09
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ	0.00	0.00

Эрдэнэс Баянбогд ХХК-ний 2025 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

3.1	Мөнгөн орлогын дүн (+)	6,436,822,140.11	1,537,771,900.00
3.1.1	Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан	6,436,822,140.11	1,537,771,900.00
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00
3.2.1	Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн мөнгө	0.00	0.00
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн	0.00	0.00
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	6,436,822,140.11	1,537,771,900.00
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	280,325,150.08	-321,906,443.49
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	71,003,120.97	351,328,271.05
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	351,328,271.05	29,421,827.56

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

№	Үзүүлэлт	Х/н	2024 оны гүйцэтгэл	2025		Харьцуулалт			
				Төлөвлөгөө	Гүйцэтгэл	2024 оны гүйцэтгэл/2025 оны гүйцэтгэл	Хувь	2025 оны төлөвлөгөө/2025 оны гүйцэтгэл	Хувь
Бүтээгдэхүүн үйлдвэрлэлт гол нэр төрлөөр:									
1		м.төг							
2	Нийт орлого	м.төг	-						
3	Нийт зардал	м.төг	762,400.90	1,659,930.90	1,021,499.30	(259,098.40)	74.6	638,431.60	61.54
	Үүнээс: Удирдлагын зардал	м.төг	762,400.90	1,659,930.90	1,021,499.30	(259,098.40)	74.6	638,431.60	61.54
4	Татварын өмнөх ашиг	м.төг	(759,979.90)	(1,659,930.90)	(1,061,419.30)	301,439.40	71.6	(598,511.60)	63.94
5	Цэвэр ашиг /алдагдал/	м.төг	(683,981.90)	(1,659,930.90)	(1,059,331.00)	375,349.10	64.6	(600,599.90)	63.82
6	Төсвийн төлбөрт нийт дүн	м.төг	188,836.70	225,551.89	207,187.60	(18,350.90)	91.1	18,364.29	91.86
	а/ НДШ	м.төг	135,940.90	162,840.00	135,057.20	883.70	100.7	27,782.80	82.94
	б/ Хүн амын орлогын татвар	м.төг	52,895.80	62,711.89	72,130.40	(19,234.60)	73.3	(9,418.51)	115.02
8	Нийт ажиллагсадын тоо	хүн	16.00	18.00	11.00	5.00	145.5	7.00	61.11
9	Нийт цалингийн сан	м.төг	51,948.70	73,300.00	40,860.00	11,088.70	127.1	32,440.00	55.74
10	Нэг ажиллагчийн дундаж цалин	м.төг	2,800.00	3,000.00	3,000.00	(200.00)	93.3	-	100.00
11	Борлуулалтын 1 төгрөгт ноогдох зардал	м.төг	-			-	0.0	-	0.00
12	Хөрөнгө оруулалт	м.төг	-			-	0.0	-	0.00
13	Нийт авлага	м.төг	14,016.60		204,394.70	(190,378.10)	6.9	(204,394.70)	0.00
14	Нийт өглөг	м.төг	7,598,869.60	10,300,000.00	8,855,744.60	(1,256,875.00)	85.8	1,444,255.40	85.98
	Богино хугацаат өр төлбөр	м.төг	6,436,822.10	2,916,027.00	-	6,436,822.10	0.0	2,916,027.00	0.00
	Урт хугацаат өр төлбөр	м.төг	881,150.60	7,383,973.00	8,855,744.60	(7,974,594.00)	10.0	-	0.00
	ДҮН		8,564,123.80	12,185,482.79	10,288,826.20	(1,724,702.40)	83.237	1,896,656.59	84.44

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 27,188.7 мянган төгрөгийн 2 алдаа¹ илэрснийг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэж, баталгаажуулав. Үүнд:

Залруулсан алдаа:

- Улсын тэмдэгтийн хураамжийн 140.4 мянган төгрөгийг байгууллагаас авах авлагаар бүртгэснийг;
- Санхүүгийн тайлан дахь биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэлийг тодруулгын тайланд 20,359.9 мянган төгрөгөөр дутуу бүртгэсэн, цалингийн өглөг дансны эхний үлдэгдэл 358.8 мянган төгрөгийг тодруулгын тайланд дансны өглөгөөр бүртгэсэн, орлого үр дүнгийн тайлан дахь ерөнхий ба удирдлагын зардлын нийт дүнг тодруулгын тайланд 6,329.5 мянган төгрөгөөр дутуу бүртгэснийг;

Эдгээр нь НББОУС 1 Санхүүгийн тайлангийн толилуулга 1.27-д “санхүүгийн тайланд байгууллагын санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг үнэн зөв толилуулах ёстой”, MNS-6817-4:2020 стандартын 5.2.1.7.2 “иж бүрэн байх-санхүүгийн тайланд өгөх дүгнэлтэд нөлөөлж болзошгүй гүйлгээ, үйл явдал, дансны үлдэгдэл, тодруулгыг орхигдуулалгүй тусгасан байх” гэж заасантай нийцэхгүй, санхүүгийн тайлагналын “нийцсэн бөгөөд зохистой байх”, “үнэн зөв байх”, “иж бүрэн байх”, батламж мэдэгдлийг хангахгүй байгааг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэж заасны дагуу залруулга хийлгэж санхүүгийн тайланг баталгаажуулав.

Аудитаар нийт 45,593.6 мянган төгрөгийн 3 зөрчил² илэрснээс, 17,694.6 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага хүргүүлж, 27,898.9 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгсөн.

Нийт залруулагдаагүй 45,593.6 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс бага тул “Өөрчлөлтгүй” дүгнэлт өгсөн.

3.1 Албан шаардлага

1. Тайлант оны эцэст урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 14,546.8 мянган төгрөг, бусад авлага дансны үлдэгдэл 3,147.8 мянган төгрөг, нийт 17,694.7 мянган төгрөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5-д “Дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”; гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын “үнэн зөв байх”, “иж бүрэн байх” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/;

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Шийдвэрлэсэн нь: Харилцагчтай авлагын үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй зөрчлийг зогсоож, дахин гаргахгүй байх албан шаардлага өгсөн.

2. Үр дүнгийн урамшуулалын 19,792.5 мянган төгрөгийг байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр олгосон нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх", 16.5.1-д "төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах"; Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Цаашид алдаа зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага өгсөн.

3.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Шатахууны норм нормативтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтыг 100 км-т зарцуулах шатахууны норм нормативаар шатахууны тооцоо боддоггүй, жолоочийн авсан 8,106.5 мянган төгрөгийг шууд зарлагадсан байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно"; 20.2.3-д "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах"; Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 390 дугаар тушаалын 3 дугаар хавсралтын 1.3-д "Авто тээврийн хэрэгсэл бүхий аж ахуйн нэгж, байгууллага, иргэд нь автомашины шатахуун зарцуулалтын үндсэн нормыг автомашины 100 км гүйлтэд зарцуулах жишиг нормыг үндэс болгон өөрсдөө тогтоож мөрдөнө" гэж заасантай нийцээгүй, санхүүгийн тайлагналын "үнэн зөв байх", "иж бүрэн байх" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шатахууны тооцоог шатахуун зарцуулалтын норм нормативын дагуу бодож байх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20.5 дахь заалтад тусгасны дагуу аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор, биелэлтийг 2026 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

4.1. Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	
								Тоо	Дүн
1	Татварын байгууллагаас авах улсын тэмдэгтийн хураамжийг байгууллагаас авах авлагаар бүртгэсэн	1	140.4					1	140.4
2	Санхүүгийн тайлан дахь биет бус хөрөнгийн эцсийн үлдэгдэл санхүүгийн тайлангийн тодруулгын дүн 20,359.9 мянган төгрөгөөр, цалингийн өглөг дансны эхний үлдэгдэл 358.8 мянган төгрөгийг тодруулгын тайланд дансны өглөгөөр бүртгэсэн, орлого үр дүнгийн тайлан дахь ерөнхий ба удирдлагын зардлын дүн тодруулга тайланд 6,329.5 мянган төгрөгөөр тус тус зөрүүтэй бүртгэсэн	1	27,048.3					1	27,048.3
	Дүн	2	27,188.7					2	27,188.7

4.2. Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
		Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Тайлант оны эцэст урьдчилж төлсөн тооцоо дансны үлдэгдэл 14,546.8 мянган төгрөг, бусад авлага дансны үлдэгдэл 3,147.8 мянган төгрөг, нийт 17,694.7 мянган төгрөгийг харилцагч байгууллагатай тооцоо нийлж, баталгаажуулаагүй	1	17,694.65			1	17,694.65		
2	Үр дүнгийн урамшуулалын 19,792.5 мянган төгрөгийг байгууллагын даргын тушаал шийдвэргүйгээр олгосон	1	19,792.5			1	19,792.5		
3	Шатахуун зарцуулалтыг түүврээр үзэхэд автомашины 100 км-т зарцуулах шатахууны норм нормативаар шатахууны тооцоо боддоггүй, жолоочийн авсан шатахууны дүнгээр шууд зарлагдсан байна:	1	8,106.49					1	8,106.49
	Дүн	3	45,593.64			2	37,487.15	1	8,106.49

4.3. Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган
төгрөгөөр/

д/д	Зөрчлийн товч утга	Нийт зөрчил					
				Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил						
1	Хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг хугацаа хоцроосон, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээний хавсралт файлууд /шийдвэрийн хуулбар/-ыг байршуулаагүй	1	0			1	0
	Дүн	1	0			1	0